



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/35

Хэрлэн сум

Нууц баримт бичгийн тооллого
явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам”-ын 12.1, 12.2, 12.4, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 213 дугаар зарлиг, “Монгол Улсын Батлан хамгаалахын төрийн болон албаны нууцыг хамгаалах журам”-ын 20 дугаар бүлгийн 20.1 дэх, заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дайчилгааны бэлэн байдлын онц чухал нууц, нууц баримт бичиг, ном материалын болон архивын 2022 оны хагас жилийн тооллого, шалгалтыг 6 дугаар сарын 02-ноос 03-ны өдрүүдэд явуулсугай.

2. Тооллогын комиссыг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Тооллогын комиссын


дарга: Н.Хүрэлээ Цэргийн штабын дарга, Хурандаа

Гишүүд: Б.Дарханбаатар Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

С.Галбадрах Цэргийн штабын Орон нутгийн хамгаалалт, сургалт хариуцсан офицер хошууч

3. Цэргийн штабын дайчилгааны бэлэн байдлын онц чухал нууц, маш нууц, нууц баримт бичиг, ном материалын 2022 оны хагас жилийн тооллогыг заасан хугацаанд чанартай явуулж материалыг Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабын Бодлого, стратегийн төлөвлөлтийн газарт хүргүүлж, 2022 оны 6 дугаар сарын 15-д илтгэхийг тооллогын комисс (Н.Хүрэлээ)-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР